

ЦАХИМ СОНИН-2022 ОНЫ 2-УЛИРАЛ №1

МБЗТЗХолбоо нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар БХБЯ болон салбарын мэргэжлийн байгууллагуудтай хамтран зураг төслийн салбарын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, гишүүн байгууллагуудын түвшинг дээшлүүлэх, инженер, техникийн ажилчдын чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

- МБЗТЗХ-ны 2021 оны бүх гишүүдийн хурлыг 2022.01.29-нд хуралдаж нийт 51 гишүүн оролцов. 2021 оны ажлын тайлан, хяналтын зөвлөлийн тайлан, холбооны санхүүгийн тайланг хэлэлцэв. Удирдах зөвлөлийн нөхөн сонгуулиар Б.Бат-Орших “МУЗИ”, Г.Алдарсайхан “Эдшил” ХХК-ийн дэд захирал, Я.Сумхүү “Сонголт дизайн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Д.Гантулга “МУЗИ” нар шинээр сонгогдов.
- Мөн холбооны Хяналтын зөвлөлийн гишүүнээр “Ар төгөл” ХХК-ийн ерөнхий инженер Ч.Цэцэг, “Молонгоо” ХХК-ийн захирал Н.Уранчимэг нарыг сонгов.

1.2. Удирдах зөвлөлийн хурал

- 2022.01.26-ны хурлаар: МБЗТЗХ-ны 2022 оны төлөвлөгөө, санхүүгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэж бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

- 2022.02.16-ны хурлаар: МБЗТЗХ-ны 2022 оны төсөв, Орон тоо, бүтэц, цалингийн фонд хэлэлцэж батлав.
- 2022.02.25-ны хурлаар: МБЗТЗХ-ны Хөдөлмөрийн дотоод журам, Мэргэжлийн хороодын бүрэлдэхүүнийг хэлэлцэж батлав.

1.3. Хяналтын зөвлөлийн хурал

- МБЗТЗХ-ны 2021 оны тайлан, санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн талаарх Хяналтын зөвлөлийн тайланг бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэв.

1.4. Бодлогын зөвлөл

- Холбооны 2021 оны тайланг 2022.01.26-нд БҮХ гишүүдийн хурлаар оруулах. Хөдөлмөрийн хууль шинэчлэн гарсантай холбогдуулан “Хөдөлмөрийн дотоод журам”-ийг шинэчлэн боловсруулах, дагалдах журмуудыг өөрсдийн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулах зөвлөмж өгсөн.

Хоёр. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

2.1. Норм дүрэм боловсруулах

- “Орон сууцны барилгад тавигдах ерөнхий шаардлагууд гарын авлага” “Өрх” ХХК боловсруулж дууссан. БХТ-тэй байгуулсан гэрээг дүгнэв
- Архивын барилгын төлөвлөлт стандарт батлагдсан. Үлдэгдэл санхүүжилтийг Архивын ерөнхий газраас авч, боловсруулсан гишүүдэд хуваарилан олгов.

2.2. Дүрэм журамд санал гаргах

- БХТ-өөс 2022.01.31-ний өдрийн 1/193 тоот албан бичгээр ирүүлсэн “MNS GOST; MNS GB/T” ангиллын 8 стандартуудад санал авахаар ирүүлсний хариуг 2022.02.15-ны 03/004 тоотоор саналыг БХТ-д хүргүүлэв.
- БХТ-өөс 2022.03.15-ны 1/518 тоот албан бичгээр ирүүлсэн “Цооногт прессиометрийн туршилт хийх MNS” төслийн саналыг 2022.03.22 -ны 03/13 тоотоор БХТ-д хүргүүлэв.
- БХТ-өөс 2022.03.15-ны 1/1517 тоот албан бичгээр ирүүлсэн “Нэр томьёоны MNS EN 16310: -2022-ын төслийн саналыг БХТ-д 03/14 тоотоор хүргүүлэв.
- БХБЯ-ны 2022.04.26-ны 3/2028 тоотоор ирүүлсэн “Зураг төслийн үе шат түүний бүрдэл дүрэм”-ийн техникийн даалгаварын төсөлд 2022.04.21-ны 01/24 тоотоор санал хүргүүлэв.
- БХТ-ийн 2022.05.12-1/1100 тоотоор ирүүлсэн Масс бетон БД-ийн төсөлд 2022.05.25-ны 03/34 тоотоор хариу санал хүргүүлэв.
- БХБЯ-наас 2022.01.29-нд Бодлогын зөвлөлийн хурлаар танилцуулсны дагуу “Барилга байгууламийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн өөрчлөлтийн талаарх санал, төсөл боловсруулж 2022.03.04-нд хүргүүлсэн.

Гурав. Төрийн байгууллагын чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд:

- Түншлэлийн “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-тай хамтран Барилгын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд оролцох, Монголын барилгын үндэсний ассоциацийн Түншлэлийн Хяналтын зөвлөлийн Тусгай зөвшөөрлийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хуралд суусан.
- “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх мэргэшлийн зэрэг олгох” сургалтыг зохион байгуулах хүрээнд Сургалтын албаны 2022 оны орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулав.
- Барилга, хот байгуулалтын яамны ТНБД-ын 2022 оны А/... дугаар тушаалаар батлагдсан нэгдсэн сургалтын төлөвлөгөөнд тусгуулсаны дагуу заавал судлах багц цаг олгох сургалт 13, сонгон судлах багц цаг олгох сургалт 8, нийт 21 удаагийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад давхардсан тоогоор 394 мэргэжилтнийг хамрууллаа. Үүнд: мэргэшсэн зэрэг горилох-239, мэргэшсэн зэрэг сунгах-78, зөвлөх зэрэг горилох-11, зөвлөх зэрэг сунгах-15 инженер тус тус хамруулсан.
- Сургалтад хамрагдагсад заавал судлах багц цаг хангасан 175, сонгон судлах багц цаг хангасан 168 сургалтын гэрчилгээний эхийг бэлтгэн, хэвлэж, баталгаажуулан олгосон.

- Мэргэшлийн зэрэг горилогч, сунгагчдад зориулсан сонгон судлах багц цаг олгох сургалтын 1 хөтөлбөр шинээр, 1 хөтөлбөр шинэчлэн боловсруулав. Үүнд: “Эмнэлгийн барилгын төлөвлөлт” – 24 цаг болон “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” – 40 цагийн агуулга бүхий болно. Германы хамтын ажиллагааны нийгэмлэг GIZ-ийн “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төслийн хамтын ажиллагааны хүрээнд 4 удаагийн /Ховд, Орхон, Төв, Хэнтий, Улаанбаатар/ бүсчилсэн сургалтад “Барилгын эрчим хүчний хэмнэлтийн талаарх чадавхижуулах цахим сургалт”-ын талаар мэдээлэл хийх болон тус сургалтад хамрагдсан 365 хүнд багц цаг тооцох сургалтын гэрчилгээ олгох ажлыг хэрэгжүүлж ажиллав.

Дөрөв. Гүйцэтгэх албаны дотоод үйл ажиллагааны хүрээнд:

- МБЗТЗХ-ны Гүйцэтгэх алба нь Хөдөлмөрийн хууль шинэчлэн гарсантай холбогдуулан “Хөдөлмөрийн дотоод журам”, “Ажлын байрны тодорхойлолт”, “Хөдөлмөрийн гэрээ” зэргийг шинэчлэн батлуулж гүйцэтгэх албаны менежерүүдтэй ажлын байрны тодорхойлолтын дагуу хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулав.
- Хөдөлмөрийн дотоод журам-ын дагалдах Нууцын журам; Ажил дүгнэх журам; Бичиг хэргийн боловсруулах, албажуулах

журам; Тамга, тэмдэг ашиглах журам; Томилолтын журам; Ажилд сонгон шалгаруулах журмын төслийг боловсруулав.

- МБЗТЗХолбооны www.macd.org.mn веб сайтыг тогтмол ажиллагаатай болгож эхэлсэн.

Тав. Гишүүдэд хандсан олон нийтийн үйл ажиллагаа:

- Ахмадуудад зориулан Цагаан сарын баяраар гишүүн байгууллагуудын нийт 148 ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулсан.
- “Степпе Арена” мөсөн өргөө ордоны барилгад хэрэгжүүлсэн инженерингийн шийдэл, дэвшилтэд технологитой танилцах аялал 4 сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Архитектор, инженерүүд маань аялалдаа оролцохын зэрэгцээ Мөсөн өргөө хотхонд зохион байгуулагдаж буй Build Mongolia 2022 - Олон улсын барилга, уул уурхай, дэд бүтцийн техник, дэвшилтэд технологийн үзэсгэлэнг үзэж сонирхлоо.



BIM форум 2022

“BIM Forum-2022 Зураг төсөл” салбар хэлэлцүүлэг

Огноо: 12 April 2022

“BIM FORUM-2022” форумын “Зураг төсөл” салбар хэлэлцүүлгийг БХБЯ, Building Smart Mongolia ТББ, МАЭ, МБЗТЗХ, МБИХ, БХТ хамтран зохион байгуулав. Уулзалт хэлэлцүүлгээр BIM гэж юу болох, зураг төслийн салбарт BIM нэвтрүүлэх шаардлага, одоо хэрэгжүүлээд явж байгаа байгууллага, хувь хүмүүсийн туршлага, тулгарч буй бэрхшээл, арилгах арга зам, BIM дэмжих программын сургалт, зураг төсөлчдийн дунд нэвтэрч буй байдал, хатуу ба зөөлөн дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдал, цаашид авах арга хэмжээ зэрэг өргөн сэдвээр санал бодол, туршлагаа хуваалцлаа. “BIM FORUM-2022” барилгын материал үйлдвэрлэгчид, нийлүүлэгчид болон захиалагч, барилга угсралтын байгууллагууд руу чиглэсэн цувралаар үргэлжилж байна.



ВІD клубынхан

МБЗТЗХ-ны дэргэдэх залуучуудын ВІD клубын бүрэлдэхүүнийг шинэчилж, гишүүдэд Ц.Мөнхбаяр, Н.Аззаяа, Л.Шинэцэцэг, Д.Оюундарь, Г.Отгонжаргал, Ц.Баярхүү, А.Бэлгүүдэй, Л.Бат-Өлзий, Н.Ариунтуяа, М.Сандалхан зэрэг залуучууд орсон ба тэргүүнээр нь ХАС-ын инженер Б.Бат-Оршихыг сонголоо.




ВІD клубын гишүүд Ц.Мөнхбаяр, Л.Шинэцэцэг, Д.Оюундарь, Г.Отгонжаргал, А.Бэлгүүдэй, Ц.Баярхүү нар мод тарих, Спорт наадам зэрэг арга хэмжээний үеэр зохион байгуулалтын ажилд гар бие оролцон тусалж ажилласанд талархал илэрхийлье!



ВІD клубын гишүүд 2022 оны 5 сарын 29-ний нартай, цастай өдөр Богд ууланд явган аялал хийлээ. Аяллын үеэр “Багийн үнэ цэнтэй гишүүн байх нь” сэдэвт үнэ цэнтэй сургалт авлаа. Уулын бэлд нартай дулаахан байвч, уулын оройд цастай хүйтэн байсан нь залуучуудад бас нэгэн тэвчээр хатуужлын сорилт болсон ч хөгжилтэй сайхан аялцгаалаа.



Хамтын ажиллагаа



Эрчим хүчний хэмнэлттэй цонх, хаалга, шилэн хийцийн холбоотой хамтран ажиллах хүрээнд Цонх хаалганы угсралтын альбом боловсруулахаар тохиролцов.

Мөн Гүйцэтгэгч байгууллагуудын холбооны Ерөнхийлөгч Б.Жүгдэртэй сургалтын чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож, эхний сургалт болох Зөвлөхийн ур чадвар сургалтыг хамтран явуулсан ба цаашид дадлагын сургалтуудыг хамтран явуулахаар боллоо.



Шинээр элссэн гишүүн байгууллагуудад батламж гардуулав.

Тус холбоонд шинээр элссэн Урбан девелопмент консалтинг ХХК, Уран асар ХХК, Сонголт дизайн ХХК, Скалайн дизайн ХХК, Эрхэс констракшн ХХК, Зэт прожект, Хээрнүүд, Бум-Асар ХХК-д гишүүний батламжийг гардуулав.





Тэрбум мод тарих хөдөлгөөнд нэгдэж Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажлыг зохион байгуулж, суулгац худалдаж авах захиалга өгч, гэрээ байгуулснаар гишүүн байгууллагууд 154 мод тарьсан байна.



Спорт наадам (спортын Ширээний теннис, Дартс, Шатар, Волейбол, Сагсан бөмбөг 5 төрлөөр) Спорт наадамыг 5 сарын 8-наас 22-ны өдрүүдэд зохион байгуулж 44 гишүүн байгууллагуудын 450 гаруй тамирчид хамрагдав. Тэмцээнийг “Хайдро дизайн прожект” ХХК “PCDP” ХХК, “Интеллект тауэр” ХХК, “Монхидро констракшн” ХХК, “Аслаан” ХХК, Сонголт дизайн ХХК, “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ байгууллагууд нийт 8.7 сая төгрөгөөр ивээн тэтгэсэн.

Тус спортын арга хэмжээнд "МОНХОРУС" ХХК-ийн баг тамирчид “АВАРГА БАГ”-аар шалгарав.



1.1. Ширээний теннисний тэмцээн, эрэгтэй ганцаарчилсан төрөлд:
 1-р байр Ж.Лхагвасүрэн "Харандаа" ХХК
 2-р байр З.Пүрэвсүрэн "Эрчим төсөл" ХХК
 3-р байр С. Бадамгарав "Эрчим төсөл" ХХК



1.2. Ширээний теннисний тэмцээн, эмэгтэй ганцаарчилсан төрөлд:

1-р байр Б.Эрдэнэзаяа "Монхорус" ХХК
 2-р байр Ц. Мөнхгэрэл "Скайлайн дизайн" ХХК
 3-р байр Г. Баасанхүү "Шүрэнэкспресс" ХХК



1.3. Холимог хосын төрөлд:

1-р байр Эрдэнэзаяа, Бат-Оргил "Монхорус" ХХК

2-р байр Ж.Лхагвасүрэн, О.Баасанхүү "Харандаа"

ХХК "Шүрэн экспресс" ХХК

3-р байр М.Мичидмаа, Б.Дөлгөөнмөрөн

"Пи Си Ди Пи" ХХК



2. Дартсын тэмцээн

1-р байр "Монхорус" ХХК-ийн баг

2-р байр "Базура дизайн" ХХК-ийн баг

3-р байр "Криетив Монголиа" ХХК-ийн баг



3. Гар бөмбөгийн тэмцээн, эрэгтэй баг:

1-р байр "Хайдро дизайн проект" ХХК



2-р байр "NCD групп" ХХК



2-р байр "Монхидро констракшн" ХХК



3-р байр "ББСМО" ХХК



3-р байр "М Си Эс Проперти" ХХК



3.1. Гар бөмбөгийн тэмцээн, эмэгтэй баг:

1-р байр "ББСМО" ХХК



Зохион байгуулагч "МОНХИДРО КОНСТРАКШН" ХХК / гар бөмбөг /-ийн "ШИЛДЭГ ТОГЛОГЧ"-дыг тодруулж, мөнгөн шагналаар шагналаа.

Гар бөмбөгийн төрлөөр, эрэгтэй "ШИЛДЭГ ТОГЛОГЧ"-оор Э. УРТНАСАН "ББСМО" ХХК, эмэгтэй "ШИЛДЭГ ТОГЛОГЧ"-оор Л.БЯМБАЖАВ- "ББСМО" ХХК нар шалгарав.



4. Сагсны тэмцээн, эрэгтэй баг:
1-р байр "М Си Эс Проперти" ХХК



2-р байр "ББСМО" ХХК



3-р байр "NCD групп" ХХК



4.1. Сагсны тэмцээн, эмэгтэй баг:
1-р байр "NCD групп" ХХК



2-р байр "ББСМО" ХХК



3-р байр "Монхорус" ХХК



Сагсан бөмбөгийн төрлөөр, эрэгтэй "ШИЛДЭГ ТОГЛОГЧ"-оор Н.АДЪЯА-"MCS ПРОПЕРТИ" ХХК, эмэгтэй "ШИЛДЭГ ТОГЛОГЧ"-оор Н.МИШЭЭЛ-"NCD ГРУПП" нар шалгарч зохион байгуулагч Ричмон консалтинг ХХК-ийн нэрэмжит шагнал хүртлээ.



5. Шатрын тэмцээн, эмэгтэй баг:

- 1-р байр С. Цэнд "Оргил төсөл" ХХК
- 2-р байр Б. Мөнхзул "Пи Си Ди Пи" ХХК
- 3-р байр Ц. Түвшинжаргал "Монхорус" ХХК



Шатар тэмцээн, эрэгтэй баг:

1-р байр Ч. Мижиддорж "Монхидро констракшн" ХХК

2-р байр Л. Болд "ОСИБ-ЗТ" ХХК

3-р байр Н. Цэрэнпунцаг "Пи Си Ди Пи" ХХК



Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо үүсгэн байгуулагдсаны 15 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан таван төрөлт "СПОРТ НААДАМ-2022" амжилттай зохион байгуулагдаж хаалтын ёслол, шагнал гардуулах ажиллагаа ҮЭ-ийн төв ордны спорт зааланд 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 20:00-21.30 цагт болж өнгөрлөө. Хаалтын ажиллагаанд гишүүн байгууллагууд, МБЗТЗХ-ны гүйцэтгэх ажлын алба, гишүүн байгууллагуудын тамирчид 44 гишүүн байгууллагын 450 гаруй хүмүүс оролцлоо.

**“СПОРТ НААДАМ-2022”-Д ОРОЛЦОЖ
ШАГНАЛТ БАЙР ЭЗЭЛСЭН БАГ
ТАМИРЧДАДАА ХАЛУУН БАЯР
ХҮРГЭЕ.**

